



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
иргэдийг хүйтний улирлын хувцсаар хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2025 оны А/463 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд 2025-2027 онд алба хаахаар элссэн иргэдийг хүйтний улирлын хувцсаар хангаж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд элссэн иргэдийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хувцас хэрэглэлийн зардлыг хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах зардал 5,250,000 (таван сая хоёр зуун тавин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 06 сарын 27-ны өдрийн
8/176 захирамжийн хавсралт



Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн хүйтний
улирлын хувцасны зардлын тооцоо

Д/ Д	Хувцас хэрэглэлийн нэршил	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Малгай (өвлийн ноосон)	6 ширхэг	30,000	180,000
2	Хүрэм өмд (өвлийн)	6 хос	270,000	1,620,000
3	Гутал (өвлийн)	6 хос	240,000	1,440,000
4	Цэрэг бүс	6 ширхэг	80,000	480,000
5	Ноосон цамц	6 ширхэг	90,000	540,000
6	Хүзүүний ороолт	6 ширхэг	40,000	240,000
7	Бээлий	6 хос	25,000	150,000
8	Аранз	6 ширхэг	100,000	600,000
Нийт				5,250,000